



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/521

Чингис хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 181 дүгээр тогтоол, Аймгийн Онцгой комиссын 36 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймаг, сум, баг хот хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг Улсын Онцгой комиссоос тогтоосноос бусад тохиолдолд 2020 оны 11 дүгээр сарын 17-ны 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд хязгаарласугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн ам олноор цугларах газрууд болох барааны зах, худалдааны төв, сүм хийд, бар зоогийн газар, ресторан, караокены үйл ажиллагааг 11 дүгээр сарын 17-ны 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний 06:00 хүртэлх хугацаанд зогсоож, архи, согтууруулах ундааг худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг мөн хугацаагаар хориглосугай.

3. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Баян-Овоо, Баянхутаг, Галшар, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх сумдын аймаг, сум баг, хот хоорондох тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаагаар хязгаарлаж, мөн сумдын хүнсний дэлгүүрийг 09:00-19:00 цаг, эмийн сан, шатахуун түгээх станц, усан санг ердийн цагийн хуваариар ажиллуулах, Чингис хотын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон Эвт худалдааны төвийн түлээ нүүрсний худалдаанаас бусад худалдааг тодорхойгүй хугацаагаар хязгаарласугай.

4. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлж хавсралтаар баталсугай.

5. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын 0-12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд /ганц бие эцэг/ байгууллагын хэвчин үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр гэрээсээ ажиллах боломжийг бүрдүүлж, цалин хөлсийг ажилласанд тооцож олгохыг байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад үүрэг болгосугай.

6. Төрийн байгууллагын ажиллах цагийн хуваарийг 09:00-12:00, 14:00-16:00 хүнсний дэлгүүр, хүнсний захын ажиллах цагийн хуваарийг 09:00-19:00 цагаар тогтоож, шатахуун түгээх станц, эмийн сан, усан санг ердийн цагийн хуваарийн дагуу халдвар хамгаалалтын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллуулсугай.

7. Үзвэр, үйлчилгээний газрууд болон слон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоосон хугацаагаар хязгаарласугай.

231010971

2.

8. Бүх нийтийн бэлэн байдлын үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомстол үүсгэхгүй байхыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч, хүнсний худалдаа эрхлэгч нарт үүрэг болгосугай.


9. Хүнсний хэрэгцээт бараа худалдан авах, эмийн болон эмнэлгийн үйлчилгээ авахаас бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг нийт иргэдэд анхааруулсугай.

10. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймаг, сумдын шуурхай штаб, шалган нэвтрүүлэх цэгийн томилгоог 2020 оны 11 дүгээр сарын 17-ны 16:00 цагийн дотор хийж баталгаажуулахыг Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

11. Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үүссэн цагийн байдалд уялдуулан зарцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

12. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

№	Байгууллагын нэр
Зайнаас ажиллах байгууллага	
1.	Аймаг, сумын ИТХ
2.	Авто тээврийн төв
3.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
4.	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс
5.	Статистикийн хэлтэс
6.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
7.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
8.	Мал эмнэлгийн газар
9.	Харгуй ХК
10.	Хэрлэн голын сав газрын захиргаа
11.	Биеийн тамир, спортын газар
12.	Боловсрол, соёл, урлагийн газар
13.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
14.	Музей
15.	Номын сан
16.	Хан Хэнтий чуулга
17.	Политехник коллеж
18.	Орон нутгийн өмчийн газар
19.	Санхүүгийн хяналт, аудитын алба
20.	Татварын хэлтэс
21.	Улсын бүртгэлийн хэлтэс
22.	Насан туршийн боловсрол төв
23.	Прокурорын газар
24.	Төрийн аудитын газар
25.	Шуудан үйлчилгээний газар
26.	Аймгийн шүүх
27.	Нийгмийн даатгалын хэлтэс
28.	Өндөрхаан нисэх буудал
Ажлын богиносгосон цагаар ажиллах байгууллага /09:12-14:16 цаг/	
1.	Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар
2.	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар
3.	Нийтлэг үйлчилгээний газар ОНӨҮГ
4.	Ус, цаг уур, орчин шинжилгээний төв
5.	Хүнс, хөдөө аж ахуйн газар
Хязгаарлалт тотоохгүй хэвийн ажиллах байгууллага	
1.	Мэргэжлийн хяналтын газар
2.	Хот тохижилт үйлчилгээний газар
3.	Хэнтий-Ус ХХК
4.	Цахилгаан түгээх сүлжээ салбар
5.	Цахилгаан холбоо
6.	Мэдээлэл холбоо сүлжээ
7.	Эрүүл мэндийн газар
8.	Зооноз өвчин судлалын үндэсний төв
9.	Уламжлалт анагаах ухааны төв

10.	Онцгой байдлын газар
11.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги
12.	Шүүхийн шинжилгээний алба
13.	Цагдаагийн газар
14.	Нэгдсэн эмнэлэг
15.	Тагнуулын хэлтэс
16.	Арилжааны банк /зөвхөн төлбөр, тооцооны үйл ажиллагаа ажиллана/
17.	Цахилгаан дамжуулах, түгээх байгууллага